

Төсөл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны дугаар сарын ...-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДЭД
НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫГ ХАРГАЛЗАН ҮРИЙН ЧАНАРЫГ БАТАЛГААЖУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ УРГАМЛЫН ТӨРӨЛ, ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

Монгол оронд үрийг нь баталгаажуулах шаардлагатай үр, хүнсний болон тэжээлийн зориулалтаар тариалдаг ба хэрэглэдэг ургамлуудын жагсаалтыг тус оронд тариалдаг ургамал, дэлхийн 83 орныг “оролцогч-орон”-оор эгнээндээ нэгтгэсэн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллагын “Үрийн схемийн дүрэм, журам” болон үрийн импортын ихэнх хувийг оруулж ирдэг ОХУ, мөн бусад орны холбогдох хууль журамд тусгагдсан ургамлуудын үндэслэн гаргав (хүснэгт 1).

Хүснэгт 1. Үрийн схемд баталгаажуулалтын шаардлагатай
сонголтын шалгуурыг хангах ургамлын зүйл

Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр
1. Үр тарианы ургамал	
<i>Avena spp.:</i>	Хошуу будааны зүйл:
<i>Avena Sativa l.</i>	Таримал хошуу будаа
<i>Avena Nuda l.</i>	Нүцгэн хошуу будаа
<i>Fagopyrum esculentum Moench</i>	Сагаг будаа, гурвалжин будаа
<i>Hordeum Vulgare (l.)</i>	Эгэл арвай
<i>Oryza Sativa (l.)</i>	Таримал цагаан будаа
<i>Secale Cereale (l.)</i>	Таримал хөх тариа
<i>Sorghum Bicolor (l.) Moench</i>	Сорго
<i>Sorghum sudanense</i>	Суданы сорго
<i>Sorghum ssp.</i>	Соргын бусад зүйл
<i>Triticum Aestivum (l.)</i>	Зусах зөөлөн буудай
<i>Triticum Turgidum l. subsp. Durum (desf.) Husn.</i>	Хатуу буудай
<i>Triticum Spelta (l.)</i>	Спелт буудай
<i>X tritico-secale wittm.</i>	Тритикале
<i>Zea Mays (l.)</i>	Эрдэнэ шиш
2. Тэжээлийн өвслөг ба буурцагт ургамал	
<i>Alopecurus pratensis (l.)</i>	Нугын үнэгэн сүүл
<i>Agropyron cristatum (l.) Gaertn.</i>	Саман ерхөг
<i>Agropyron desertorum (fischer exlink) schultes</i>	Цөлийн ерхөг
<i>Agropyron spp.</i>	Ерхөгийн бусад зүйл
<i>Agrostis spp</i>	Улаан толгойн зүйл
<i>Agrostis gigantea roth</i>	Аварга улаан толгой
<i>Agrostis stolonifera (l.) [incl. A. Palustris hudson]</i>	Найлзуурт улаан толгой
<i>Bothriochloa spp.</i>	Биелэгийн бусад зүйл
<i>Bothriochloa insculpta (a. Rich) a. Camus</i>	Мөлхөө биелэг
<i>Bromus arvensis (l.)</i>	Хээрийн согоовор
<i>Bromus inermis leysser</i>	Соргүй согоовор
<i>Bromus erectus hudson</i>	Босоо согоовор

<i>Bromus spp</i>	Согооврын бусад зүйл
<i>Elytrigia repens (l.) Desv.ex nevski</i>	Мөлхөө хиаг
<i>Elytrigia spp</i>	Хиагны бусад зүйл
<i>Medicago lupulina (l.)</i>	Зүргийлэг царгас
<i>Medicago sativa (l)</i>	Таримал царгас
<i>Medicago rugosa desr</i>	Атираат царгас
<i>Medicago spp</i>	Царгас зүйл
<i>Melilotus officinalis lam</i>	Эмийн хошоон
<i>Melilotus spp</i>	Хошооны зүйл
<i>Trifolium pratense (l.)</i>	Нугын хошоонгор
<i>Trifolium repens (l.)</i>	Мөлхөө хошоонгор
<i>Trifolium spp</i>	Хошоонгорын зүйл
3. Тоонолжин цэцэгт ба бусад тосны болон техникийн ургамал	
<i>Brassica juncea l. Czernj. Et cosson</i>	Гаймуу байцаа
<i>Brassica oleracea var. italica</i>	Цэцэгт байцаа
<i>Brassica rapa var. pekinensis</i>	Бээжин байцаа
<i>Brassica nigra (l.) Koch</i>	Гич
<i>Brassica napus (l.)</i>	Рапс
<i>Brassica rapa (L.)</i>	Манжин
<i>Camelina spp</i>	Тэмээлжийн бусад зүйл
<i>Cannabis sativa L.</i>	Таримал олс
<i>Carum carvi L.</i>	Эгэл гоньд
<i>Cichorium intybus L.</i>	Эгэл идрээ
<i>Gossypium hirsutum L.</i>	Хөвөн
<i>Helianthus annuus L</i>	Наранцэцэг
<i>Linum usitatissimum L.</i>	Эгэл маалинга
<i>Papaver somniferum L.</i>	Намуу
4. Хүнсний ногоо	
<i>Allium cepa</i>	Бөөрөнхий сонгино
<i>Allium sativum l.</i>	Улаан хальст сармис
<i>Apium graveolens L.</i>	Цоохорт майлз
<i>Beta vulgaris (L.)</i>	Чихрийн манжин
<i>Capsicum annuum L</i>	Гашуун чинжүү
<i>Capsicum</i>	Чинжүү
<i>Citrullus lanatus (Thumb) Mansf.</i>	Тарвас
<i>Cucurbita maxima Duchesne</i>	Хулуу
<i>Cucumis sativus</i>	Өргөст хэмх
<i>Daucus carota</i>	Лууван
<i>Ipomoea batatas</i>	Амтат төмс
<i>Pimpinella anisum L</i>	Гоньд
<i>Raphanus sativus (L.)</i>	Улаан лууван
<i>Solanum tuberosum</i>	Төмс
<i>Solanum lycopersicum</i>	Улаан лооль
<i>Solanum pseudocapsicum</i>	Цэс
<i>Spinacia oleracea</i>	Бууцай

Үрийн сортын баталгаажуулалтын схемд үрийн ангилал тус бүрээр нь тусгай дүрэм журам боловсруулдаг. Энэ дүрэмд үрийн ерөнхий байдал, цувралын хэмжээ (партия, сери), бүх сортод болон гибридэд тавигддаг шаардлагуудыг (өмнөгч таримлууд, орон зайн тусгаарлалт, хог ургамал, зүйлийн давтамж, талбайн туршилт, сортын цэвэрлэгээ, үрийн эрүүл ахуй, сортын цэвэршилт) тусгадаг.

Хүнс, тэжээлийн зориулалттай үрийн хүнсний аюулгүй байдал, байгаль орчин, хүн, малын эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг харгалзан үрийн чанарыг баталгаажуулахад дараах үзүүлэлтүүдийг авч үзэж болох бөгөөд байж болох доод түвшинг тогтоож өгдөг (хүснэгт 2).

Хүснэгт 2. Хүнс, тэжээлийн зориулалттай ургамлын үрийн аюултай байдлын үзүүлэлт

Үрийн бүлэг	Үзүүлэлтүүд		
Хүнсний үр тариа, (улаан буудай, хөх тариа, тритикале, хошуу будаа, арвай, шар будаа, сагаг, цагаан будаа, эрдэнэ шиш, сорго)	Хортой элементүүд:	Хар тугалга, хүнцэл, кадми, мөнгөн ус	
	Микотоксин:	афлатоксин В, дезоксиниваленол, Т-2 токсин, зеараленол, охратоксин	
	Нитрозамин:	нийт НДМА ба НДЭА, Бенз(а)пирен	
	Пестицид:	гексахлорциклогексан (изомерүүд), ДДТ ба түүний метаболитууд, гексахлорбензол, мөнгөн уст органик пестицидүүд, 2,4-Д хүчил, түүний давснууд, эфирүүд	
	Цацраг идэвхт нэгдлүүд:	цезий-137, стронций-90	
	Хортой хольц:	мөлхөө гич, үнэгэн сүүлт софор, харуутай үр, харга, фузариозын халдвартай үр, ягаан өнгөтэй үр, флуоресценцийн тод шар ногоон өнгөтэй үр	
Үр тарианы агуулахын хөнөөлт организмаар бохирлогдсон		шавьж, хачиг	
Буурцагт ургамлын үр (вандуй, шош, сэвэг зарам)	Хортой элементүүд:	Хар тугалга, хүнцэл, кадми, мөнгөн ус	
	Микотоксин:	афлатоксин В1	
	Пестицид:	гексахлорциклогексан (изомерүүд), ДДТ ба түүний метаболитууд, мөнгөн уст органик пестицидүүд, 2,4-Д хүчил, түүний давснууд, эфирүүд	
	Агуулахын хөнөөлт организмаар бохирлогдсон ба халдварлагдсан		шавьж, хачиг
	Цацраг идэвхит нэгдлүүд:	цезий-137, стронций-90	
Бүх төрлийн будаа, үрийн хальс, нунтаглаж зөөлрүүлсэн үр	Хортой элементүүд:	Хар тугалга, хүнцэл, кадми, мөнгөн ус	
	Микотоксин:	афлатоксин В, дезоксиниваленол, Т-2 токсин, зеараленол	
	Пестицидүүд		
	Цацраг идэвхт нэгдлүүд:	цезий-137, стронций-90	
	Агуулахын хөнөөлт организмаар бохирлогдсон ба халдварлагдсан		(шавьж, хачиг)